



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 11 дүгээр сарын 25  
№ 46 (1244)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

796. Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 66 3091

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

797. Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай Дугаар 167 3092

798. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон  
томилох тухай Дугаар 170 3092

799. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 171 3093

800. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн  
албан тушаалд томилох тухай Дугаар 172 3093

801. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 173 3094

802. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 174 3094

803. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 178 3095

804. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 179 3095

805. Элчин сайдыг тохоон томилох тухай Дугаар 183 3096

806. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 187 3096

807. Анхан шатны шүүхийн шүүгчийн  
албан тушаалд томилох тухай Дугаар 188 3097

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

808. Жагсаалт шинэчлэн батлах тухай Дугаар 215 3097



## Тайлбар

### Зөрчилтэй үзэмжтэй үйлдэл үйлдүүлэх

• ᠑᠗᠑

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх үйлдэл үйлдүүлэх

᠑᠗᠑

᠖᠗᠐᠐᠐

### Зөрчилтэй үзэмжтэй үйлдэл үйлдүүлэх

• ᠗᠑᠗

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• 7᠑᠗

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠗᠑᠗

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• 007

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• 6᠐7

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠗07

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠗0᠐7

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠙᠐7

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠒᠐07

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠑᠐7

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

• ᠗᠐7

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐

### Зөрчилтэй үзэмжтэй үйлдэл үйлдүүлэх

• 7᠐7

Хүндэтгэн, гүйцэтгэгчид, мөрдөгчид үйлдүүлэх

᠗᠑᠗

᠗᠑᠐᠐᠐



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

**Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Mongolian Folio\_02 Yellow Mongolia and Development**

Утасны номер: 96 - 06 70000  
Утасны номер: 96 06 70000

Төрийн мэдээллийн үйлчилгээний төв / State Information Service Center  
Улаанбаатар хот / Ulaanbaatar City

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДЭД ХОРООНЫ ГИШҮҮН  
Г.ЗАНДАНШАТАР

ЖИЖИГ, ДУНД  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДЭД  
ХОРООНЫ ГИШҮҮН  
Г.ЗАНДАНШАТАР

Утасны номер: 96 - 06 70000  
Утасны номер: 96 06 70000



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 210 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Зундуйн Энхтуяаг Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 08 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Мозамбик Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Одонжилийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Мозамбик Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Энхтүвшингийн Булганыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 08 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гончигийн Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбажавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 08 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар  
хот

### Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 192 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Сэргэлэнгийн Энхбаярыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 08 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Босни-Херцеговин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ганхуурайн Баттунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Босни-Херцеговин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мижиддоржийн Цэнгэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 08 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Авирмэдийн Баттөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Уламбаярын Нямхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 09 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Гэгээн Ширээт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лүндэгийн Пүрэвсүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Гэгээн Ширээт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваасүрэнгийн Гэрэлмааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 09 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гончигийн Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбажавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Доминиканы Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шагдарын Батцэцэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 187

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Лихтенштайны Хант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лүндэгийн Пүрэвсүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Лихтенштайны Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваасүрэнгийн Гэрэлмааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 188

Улаанбаатар  
хот

### Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 290 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1.Тэрбишийн Гангэрэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Тэрбишийн Гангэрэлийг Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 215

Улаанбаатар  
хот

### Жагсаалт шинэчлэн батлах тухай

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтын жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Хилийн зарим боомтоор шинээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээллийг боомт бүрээр бэлтгэж, дипломат шугамаар хөрш



улсуудтай харилцаж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтуудад гаалийн төрөлжсөн лабораториудыг байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах санхүүжилтийг зээл, тусламжийн хөрөнгөөр болон улсын төсвийн төсөлд тусгах замаар шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т тус тус үүрэг болгосугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт, дүрэм батлах тухай” Засгийн газрын 2006 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**УУЛ УУРХАЙ, ХҮНД  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Г.ЁНДОН**

Засгийн газрын 2022 оны 215 дугаар  
тогтоолын хавсралт

**ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ  
ИМПОРТЛОХ, ЭКСПОРТЛОХ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ,  
ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ ХИЛИЙН БООМТЫН ЖАГСААЛТ**

1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг авто болон төмөр замын тээврээр импортлох, экспортлох хилийн боомт:

- Дорноговь аймгийн Замын-Үүд боомт;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт;
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт;
- Дорнод аймгийн Баянхошуу боомт;
- Сүхбаатар аймгийн Бичигт боомт;
- Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомт;
- Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомт;
- Дорноговь аймгийн Ханги боомт;



- Ховд аймгийн Булган боомт;
- Дорнод аймгийн Эрэнцав боомт;
- Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомт.

2.Тээвэрлэлтийн үеийн аюулгүй нөхцөлийг хангасан тээвэрлэлийн хэрэгслийг агаарын тээвэрээр импортлох хилийн боомт:

- Олон улсын агаарын замын “Чингис хаан” боомт.

---oOo---



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 200003**